

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”-ийн хэлэлцүүлгийг Нээлттэй Нийгэм Форум нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудтай хамтран 2019 оны 10-р сарын 1-нд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт оролцогчид уг хуулийг НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын үзэл баримтлалд нийцүүлж зохицуулсныг, мөн хуульд бие даасан агентлаг байгуулж, салбар дундын тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндсийг бий болгосон зэргийг сайшаан тэмдэглэв.

Энэхүү Хуулийн шүүмжийн дугаарт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар зохицуулсан харилцааг улам боловсронгуй болгох, хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр гаргасан зарим санал, шүүмжийг нэгтгэн танилцуулж байна.

Нэг. ЕРӨНХИЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

1.1 Тус хууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүн (ХБХ гэх)-ий нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах зорилгод үйлчлэх ёстой хэдий ч хэрэгжүүлэх арга зам тодорхой бус байгаагаас төр, хувийн хэвшлийн байгууллагад хуулийг хэрэгжүүлэхэд ойлгомжгүй, тодорхойгүй байдал бий болсон. Мөн бусад хуультай уялдахгүй байгаа нь ч үүнд нөлөөлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос (ХБХЭХ) 2015 онд Конвенцын хэрэгжилтийн талаарх Засгийн газрын анхдугаар илтгэлийг хэлэлцэж гаргасан Дүгнэлт зөвлөмжид ч үндэсний хууль тогтоомжоо Конвенцод бүрэн нийцүүлэхийг зөвлөсөн билээ.¹

Санал: ХБХ-ий нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хэрхэн хангах арга зам, оролцооны хэлбэрийг хуульд нарийвчлан тусгах, нэмэлт тайлбар зүүлт оруулах, мөн холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах

1.2 Хуулийн 7.3, 8.3, 8.4, 11.3, 15.7, 15.10, 15.11, 16.4, 18.1.3, 18.1.5, 20.3, 23.2, 25.2, 32.8, 42.1.5 зүйл, заалтын хэрэгжилтийг хангах санхүүжилтийн эх үүсвэрийг тусгасан хэдий ч холбогдох бусад хууль тогтоомжид нарийвчлан тусгаагүйн улмаас тодорхойгүй байдал үүсэж хэрэгжилтэд хүндрэл учруулж байна.

Санал: Санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлэх

¹ Committee on the Rights of Persons with Disabilities, CRPD/C/MNG/CO/1, May 13, 2015, para 7(a)

1.3 Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид зааж өгөөгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, хүртээмжтэй орчныг бий болгох, сурч боловсрох, хөдөлмөрлөх, эрүүл мэндийн тусламж хүртэх зэрэг нөхцөлийг хангах чиглэлээр төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагад тодорхой үүрэг хүлээлгэсэн хэдий ч биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг орхигдуулсан нь тухайн эрх зүйн боломжийг тунхаглалын шинжтэй болоход хүргэжээ. Энэ талаар ХБХЭХ-оос өгсөн Дүгнэлт зөвлөмжид ч мөн туссан бөгөөд тухайлбал, хүртээмжтэй орчны стандартыг зөрчсөн этгээдэд шийтгэл ногдуулах, энэ чиглэлээр Конвенц болон тус хорооноос баталсан Ерөнхий зөвлөмж хоёрыг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсөн байна.²

Санал: Хүлээлгэх хариуцлагыг холбогдох хуульд тусгах

1.4 Сургууль завсардсан ХБХ-ийг сургалтад нөхөж хамруулах асуудал орхигдсон. Мөн ХБХ-д үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагыг боловсролын, асаргаа, сувилгааны зэрэг төрөл чиглэлээр ангилан төсөв, хувьсах зардлын хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн, ялгамжтай, хүртээмжтэй авч үзэх шаардлагатай байна.

1.5 Хуулийн 7-р зүйлд хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгасан ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь “хэлний бэрхшээлтэй”, “сонсголын бэрхшээлтэй” хэмээх нэршлийг хуучнаар буюу “хэлгүй”, “дүлий” гэсээр байгаа бөгөөд энэ нь ялангуяа орон нутагт түлхүү ажиглагдаж байна. ХБХЭХ-оос Конвенцын хэрэгжилтийн талаарх Засгийн газрын анхдугаар илтгэлийг хэлэлцэж өгсөн Дүгнэлт зөвлөмждөө хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхийг мөн зөвлөсөн юм.³

Санал: Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх

1.6 ХБХ-ий эмчилгээний шинэ оновчтой арга, аргачлал, санаачилга, эрдэм шинжилгээний судалгаа, шинжилгээг дэмжих асуудлыг хуульд нэмж тусгах шаардлагатай.

Хоёр. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
1	4.1.1.	“чадвар” гэсэн нэршлийг “боломж” гэж солих	Орчны саад бэрхшээлийн улмаас боломж хязгаарлагддаг.
2	5.1.5.	Илүү тодорхой болгох	Тус заалт тунхаглалын шинжтэй байгаа тул
3	6.5.2.	Гэр бүлийн гишүүд гэдэг ойлголтыг Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нийцүүлэн томъёолох, мөн асран хамгаалагч, харгалзан дэмжигч гэснийг нэмэх	Зөвхөн гэр бүлийн гишүүн гэж хязгаарлах нь асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг хамруулахгүй тул өргөнөөр томъёолох шаардлагатай.
4	7.1.3.	Боловсролын холбогдох хуульд тухайн асуудлыг тусгах замаар энэ заалтын хэрэгжилтийг хангах шаардлагатай.	Учир нь хууль хэрэгжээд 3 жил болоход энэ чиглэлээр ажил хийгдэж эхлээгүй байна.

² Зүүлт 1-ийг үзнэ үү. para 17

³ Мөн тэнд, para 15

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
5	7.3	“гэрээгээр гүйцэтгүүлж болох” гэсэн нь үгүй ч байж болох утгыг давхар илэрхийлж байгаа тул “гэрээгээр гүйцэтгүүлэх” гэж өөрчлөх, мөн “сонгон шалгаруулах журам” батлах холбогдох төрийн байгууллагыг нэмж заах	Энэ ойлгомжгүй байдлын улмаас энэ заалт хэрэгжихгүй тунхаглалын шинжтэй явж ирсэн.
6	8.3.	Тус заалтад заасан үйл ажиллагааг санаачлан зохион байгуулсан ТББ, хувийн хэвшлийг дэмжих заалт нэмж тусгах	
7		“8.2, 8.3, 8,4 дүгээр зүйлд заасан үйл ажиллагааг ХБХ-ий төлөө үйл ажиллагаа явуулдаг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж, холбогдох зардлыг тухайн асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сум дүүргийн төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн заалт нэмэх	ТББ, хувийн хэвшлээр гэрээлэн гүйцэтгүүлэх ажлыг тухай бүрд тодруулж заахгүй бол энэ ажлыг хийх боломжгүй хэмээн төрийн байгууллага тайлбарладаг.
8	9.1. 9.4.	Заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор оролцоог хэрхэн хангах талаар холбогдох журам, заавар боловсруулж, батлах үүргийг нэмж тусгах. ТББ-ын төлөөлөлд тулгуур эрхтний болон харааны бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг төлөөлж ажилладаг байгууллагыг заавал оруулах гэсэн санааг нэмж оруулах нь зүйтэй.	Дэд бүтцийн төсөлд тулгуур эрхтний, харааны бэрхшээлтэй хүмүүст тохируулга хийх зайлшгүй шаардлагатай байдаг бөгөөд тухайн бэрхшээлтэй хүнийг өөр хүмүүс төлөөлөн үнэлгээ хийх боломжгүй.
9		Мөн хуучин барилга, зам талбайн бүтээн байгуулалтыг хүртээмжтэй болгох асуудлыг шат дараатай зохион байгуулах талаар үүрэг хүлээлгэсэн заалтыг нэмж тусгах	
10	11.1.	Боломж, нөхцөлийг хэрхэн бүрдүүлэх асуудлыг холбогдох хуульд тодорхой байдлаар нэмж тусгах	Хуулийн заалт хэрэгжихгүй байна.
11	11.2.5.	“Үе шаттайгаар хэрэгжүүлэх” гэсэн үгийг хуульд тайлбарлах замаар жилээс жилд ахиц гарч байх ёстой гэсэн санааг илэрхийлэх	Үгүй бол хэрэгжүүлэх чиглэлээр огт алхам хийхгүй байна.
12	11.2.6.	“төрөөс дэмжих” гэснийг “төрөөс дэмжиж үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдон гарах аливаа төрлийн татвар, төлбөр, хураамжаас чөлөөлнө” гэж солих	Энэ зорилгоор байгуулагдсан ашгийн бус радио, телевиз нь долгион эзэмших, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн болон бусад төлбөр хураамж төлөх боломж байдаггүй.
13	12.2. 12.3.	Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг сонсголын бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах замаар боловсруулах	Учир нь дохионы хэл өөр хоорондоо ялгаатай байдаг тул олон талт төлөөлөл оролцох шаардлагатай.
14		“12.4. Дохионы хэл судалгааг хөгжүүлэх, бүртгэлжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, дохионы хэлмэрч бэлтгэх ажлыг төр бүрэн хариуцна. 12.5. Энэ хуулийн 12.4-т заасан үйлчилгээг ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно” гэсэн заалтыг нэмж тусгах	Нутгийн аялга, сурсан арга хэлбэрээс хамааран онцлог ялгаатай байдаг ч энэ чиглэлээр судалгаа хийгддэггүй.
15	14.1.3.	“...хүртээмжийг нэмэгдүүлэх” гэсэн агуулгыг нэмж тусгах	“Хүртээмж” гэдгийг “тохирох хэрэглэгдэхүүн” гэдгээс ялгаж ойлгодог тул тусад нь заах нь зүйтэй.

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
16	15.1.2.	Энэ заалтын агуулгыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад тусгах замаар хэрэгжилтийг хангах	
17	15.2.	“Бүх шатны сургалтын байгууллага” гэдэг ойлголтыг дэлгэрүүлэн “Бүх шатны боловсрол, сургалтын байгууллага” хэмээн солих	Төрийн байгууллага боловсрол, сургалтын байгууллагыг тусад нь салгаж авч үздэг.
18	15.3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа “...тухайн шатны сургалтын стандартад нийцүүлэх...” гэсэн санааг нэмэх	ХБХ-ий сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахдаа онцлогт тохируулах бус хөнгөвчилсөн байдлаар боловсруулж, хэрэгжилтийг хангахгүй байна.
19	16.4.	Дохионы хэлний шинжээчийг сургаж бэлтгэх асуудлыг нэмж тусгах	Учир нь дохионы хэл судлалын хөгжил маш сул байна.
20	17.1.	“шагнал, урамшуулал” гэж нэмэх	Ажил олгогчдын зүгээс ХБХ-д ажил олгож, цалин өгч байгаа нь их юм гэх хандлага байдаг.
21	17.6.	Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүссэн ХБХ-ий тэтгэвэр тухайн үеийн ХХДХ-г 1,5 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс бага бол зөрүүг халамжийн сангаас олгохоор тусгах	ХБХ нь өндөр насны эсхүл группийн тэтгэврийн аль нэгийг сонгоход хүрдэг бөгөөд орлого нь эрс буурдаг.
22	18.1.2.	Тодорхой квот, хувь хэмжээг тусгаж өгөх шаардлагатай. Мөн “үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг” гэснийг “үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг” гэж солих	Энэ заалтын хэрэгжилт хангалтгүй байдаг. Мөн бүтээгдэхүүн гэдгийг тодорхой эд бараа гэж ойлгодгоос үйлчилгээг орхигдуулдаг.
23	18.1.6.	ХБХ-ийг “хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ” үзүүлж байгаа байгууллагыг нэмж тусгах	Хөдөлмөрт бэлтгэх нь ХБХ-ий хөдөлмөр эрхлэлтэд чухал дэмжлэг болох бөгөөд энэ нь НҮБ-ын ХБХЭТК-д туссан.
24		“Бизнес эрхлэгч ХБХ, тэдний үүсгэл санаачилгаар байгуулагдсан аж ахуйн нэгжийг дэмжих хөтөлбөр, дэд хөтөлбөртэй байх” гэж тусгах	ХБХЭТК-д туссан бөгөөд энэ заалтыг нэмснээр ЖДҮ-ийг дэмжих холбогдох хуультай уялдуулах боломжтой болно.
25		ХБХ-д мэргэжлийн чиг баримжаа, ур чадвар олгох үйл ажиллагааг дагнан явуулж байгаа мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааны зардлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.	Суралцагсдын тоогоор хувьсах зардал авдаг ч энэ нь зардлыг санхүүжүүлэхэд хүрдэггүй. Суралцагсад ногдох багш, ажиллагсдын тоо их, тусгай орчин нөхцөл, сургалтын хэрэглэгдэхүүн, материал шаардагддаг.
26	19.1.	“ХБХ-ийг хөдөлмөрт бэлтгэх үйлчилгээ”-ний журам, заавар батлах асуудлыг нэмж тусгах	Нээлттэй сонгон шалгаруулалтад ХБХ-ий онцлог хэрэгцээг тусгах боломжтой болно.
27		Хиймэл эрхтэн, туслах хэрэгсэл нийлүүлэгч байгууллагад тавигдах шаардлагыг нэмж тусгах	
28		Мөн протез, ортопедийн хэрэгслийн стандарт, жишиг үнийг тодорхой хугацаанд шинэчилж байх асуудлыг нэмж тусгах	Одоогийн үнэ нь чанартай бүтээгдэхүүн хэрэглэх боломжийг хязгаарладаг.
29		Протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн нийлүүлэлтэд ногдох гаалийн татвараас чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг холбогдох хууль, тогтоомжид тусгах	Энэ нь хэрэглэгчид очих бүтээгдэхүүний үнэ, чанарыг зохих түвшинд байлгахад чухал ач холбогдолтой.

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
30	22.1.	“Хамруулан хөгжүүлэх” гэдэг ойлголтыг ХБХЭТК-ын үзэл санаанд нийцүүлэн томъёолох	“Хамруулан хөгжүүлэх” гэдэг ойлголт нь онолын хандлага байтал нөхөн сэргээх үйлчилгээ мэт оруулснаар хэрэгжилтэд тодорхойгүй байдал бий болгосон.
31	22.1.1. 22.1.2. 22.1.3. 22.1.4. 22.1.5.	Хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний үндсэн 5 чиглэл тус бүрт стандарт, журам, зааварчилгаа батлах үүргийг нэмж тусгах	
32	23.4.	“тавигдах шаардлага” гэсний дараа “үйлчилгээний журмыг” гэж нэмэх	Үйл ажиллагааг бүхэлд нь журамлах цогц ойлголт бий болно.
33	25.1.2.	Туслах үйлчилгээ гэж юу болох, хаанаас авах, санхүүжилтийн эх үүсвэр юу болохыг холбогдох хууль тогтоомж, журам, стандартад тусгах, үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдлыг харгалзах	Тус заалт нь хэрэгжих арга зам тодорхойгүй тул эцэг, эх үйлчилгээг авч чадахгүй байна.
34	25.2.	Засгийн газрын гишүүний болон аймаг, нийслэлийн Засаг даргын жил бүрийн төсөвт хэдэн хувиар, хэрхэн тусах квотыг тогтоох, жил бүр олон нийтэд тайлагнах үүргийг хуульд нэмж тусгах	Уг заалт хэрэгжиж байгаа эсэх нь тодорхойгүй байна.
35		“25.2.1 ХБХ-д зориулсан халамжийн орон сууцны сан бүрдүүлэх 25.2.2 халамжийн, түрээсийн орон сууцанд болон ипотекийн зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулах орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэх 25.2.3 тухайн жилд ашиглалтад орж байгаа нийт орон сууцны 5-аас доошгүй хувийг ХБХ-д ноогдохоор тооцож шаардагдах хөрөнгийг Нийгмийн хамгаалал, барилга хот байгуулалтын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний болон нийслэл, аймаг, дүүргийн төсөвт тусгах” гэж нэмэх	Энэ нь олон улсад байдаг жишиг. ХБХ-д орон сууц нэн хүртээмжгүй. Учир нь төлбөрийн чадваргүй гэсэн үндэслэлээр зээл авч чаддаггүй, түрээс болон ипотекийн зээлд хамрагдах тусгай бодлогын дэмжлэг байдаггүй.
36	26.1.5.	Тус заалт болон холбогдох хуульд ХБХ, түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчид “дугаарын хязгаарлалт” үйлчлэхгүй байх асуудлыг нэмж тусгах	ХБХ-ий хувьд нийтийн тээврийн үйлчилгээ хүртээмжгүй байгаа үед энэ заалт үр дүнтэй биш.
37	26.1.7.в	Протез, ортопед, сонсголын бэрхшээлтэй иргэдийн сонсголын аппарат, туслах хэрэгслийн үнийг 100 хувь нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлэх. Мөн сонсголын аппарат, туслах хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлэх боломжийг хуульд тусгах нь зүйтэй.	Протез, ортопед, сонсголын бэрхшээлтэй иргэдийн сонсголын аппарат, туслах хэрэгслийн үнийн 50 хувийг ХБХ гаргаж байгаа нь хүндрэлтэй байна.
38	27.2.	“... нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн туслалцаа авах” тухай нэмж тусгах	Эрх зүйн харилцаанд оролцох үед эдгээр үйлчилгээ авах зайлшгүй шаардлага үүсдэг.
39	28.1.	“хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн, оношилж, үнэлсэн” бол цаашид ямар үйлчилгээг, хэрхэн авах асуудлыг журамлах шаардлагатай. Үүний тулд “хүүхдийн хөгжлийн төв байгуулах, үйл ажиллагаа эрхлэх журам, стандартыг боловсруулан баталж, холбогдох санхүүжилтийг улс, орон нутгийн төсөвт тусгах” гэж нэмэх	ХБ-тэй ялангуяа хүнд хэлбэрийн ХБ-тэй хүүхдүүдэд тусгайлан үйлчилгээ үзүүлэх хэрэгцээ байдаг. Гэвч дээрх төвүүдэд төрөөс санхүүгийн болон бусад талын дэмжлэг огт байдаггүй учраас энэ чиглэлийн байгууллага цөөн, байгаа хэд нь үйл ажиллагаа явуулахад маш хүнд байдаг.

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
40	28.3.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид үзүүлэх нийгмийн хамгааллын болон нийгмийн халамжийн тусламж үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох	
41	28.4.	Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс холбогдох хууль тогтоомж, журамд энэ чиглэлийн үйл ажиллагааг илүү тодорхой тусгах.	Бодит байдалд ХБХ гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох эрсдэл өндөр, хамгаалал дутмаг байна.
42	28.6.	Заалтыг хэрэгжүүлэх тодорхой журам, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Хэт ерөнхий, арга зүй байхгүй байгаа.
43		“28.6.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хүүхдээ өсгөн бойжуулах, хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгоход зориулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх 28.6.2. ХБХ, хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшил, ТББ-д хуулийн 28.6.1-д заасан хөтөлбөрт нийцсэн үйл ажиллагаа явуулж, үйлчилгээ үзүүлсэн бол холбогдох зардлын тодорхой хувийг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх 28.6.3 Энэ хуулийн 28.6.1, 28.6.2-т заасан хөтөлбөр, үйл ажиллагаа, үйлчилгээ, санхүүжилтийн журмыг ХБХ-ий асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага баталж, хэрэгжүүлэх” гэж нэмэх	ХБ-тэй эцэг эхчүүдэд хүүхдээ хэрхэн өсгөн бойжуулах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх, нийгэмшүүлэх талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй байдгаас хөгжлийн бэрхшээлтэй олон хүүхдүүд бага насандаа бие даах чадваргүй, зожиг, бусад байдлаар давхар ХБ-тэй гэж ойлгогдохоор хүндэрсэн байдаг.
44		Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд хандах, олон нийтийн хандлагыг өөрчлөх тал дээр түлхүү анхаарах	Хандлага буруу байгаагаас ХБ-тэй эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал, хэрэгцээг үнэлж, тэдгээрийн онцлогт тохирсон үйлчилгээ үзүүлэх суурь тавигдаагүй байна.
45	30.1. 30.2. 30.3. 30.4.	ХБХ-ий сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулах тодорхой зүйл заалтыг Сонгуулийн холбогдох хуульд тусгах шаардлагатай. Намуудын тухай хуульд ХБХ-ий оролцоог хангах квот тогтоох, ХБХЭТК-д нийцүүлэн төрийн байгууллагын удирдлага, ИТХ-ын бүрэлдэхүүнд ХБХ-ий квот тогтоох	ХБХ-ий сонгох, сонгогдох эрх хангагдах боломж бүрдэнэ.
46	32.7.	“дотоодод сургаж бэлтгэсэн хөтөч нохойн үнийг 7 жилд нэг удаа олгож, хөтөч нохойг тэжээх, хэрэглэхэд шаардагдах зардлын 50 хувийг улс, орон нутгийн төсвөөс олгох”-оор нэмж заах	Хараагүй хүн нэг хөтөч нохойг олон улсын жишгээр дунджаар 7 жил хэрэглэдэг бөгөөд нохойг тэжээх, асрах, хэрэглэхэд хоол тэжээл, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ, ариун цэврийн бүтээгдэхүүн гэх мэт маш их зардал гардаг.
47	33.4.	Мөнгөн урамшуулал тэтгэмж олгох санг тодорхой тусгах	

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
48	37.2.3.	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ гэсэн нэршлийг хуулийн зүйл заалтаас хасах	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээнээс хамааран ХБХ-ий нийгмийн хамгаалал, халамжийн зарим эрх үүсэхгүй байх нөхцөл үүсдэг.
49		“37.2.4. 55 нас хүрсэн эмэгтэй, 60 нас хүрсэн эрэгтэйн ХБ-тэй болсон шалтгаан, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хугацааг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс тогтоох бөгөөд хуульд заасны дагуу үзүүлдэг хөнгөлөлт, чөлөөлөлт, тусламж, үйлчилгээнд ХБ-тэй өндөр настан иргэд хамрагдах эрхтэй.” гэж нэмэх	Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс өндөр настан ХБХ-д “хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох” боломжгүй гэснээс үүдэн өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ХБХ хөнгөлөлт, чөлөөлөлт, тусламж дэмжлэгт хамрагдах боломжгүй болдог.
50	37.9.	Хамт олонд түшиглэн хөгжүүлэх үйлчилгээг тодорхой болгох журам, стандарт боловсруулах үүргийг хуульд тусгах. Мөн “тус комиссын дүгнэлт нь хуульд заасан бүх үйлчилгээ, дэмжлэг, тусалцаа, хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах үндсэн баримт бичиг болно” гэсэн санааг нэмэх	Учир нь комиссын дүгнэлтийг бүх үйлчилгээ, дэмжлэг, тусалцаа, хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдахад үндэслэл болгодог.
51		39.1.5-ыг 39.1.6 болгож, 39.1.5-д “МУ-ын ЗГ, төрийн бүх шатны байгууллага, орон нутгийн байгууллагаас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, бодлогын баримт бичиг, аливаа шийдвэрт ХБХ-ий эрхийг хангах асуудлыг заавал тусгаж, хэрэгжилтийг хангах” хэмээн заалт нэмэх	Төрөөс гаргаж байгаа аливаа шийдвэр, бодлогын баримт бичиг, төсөл хөтөлбөрт ХБХ-ий асуудлыг заавал тусгадаг, саналыг авдаг хөгжсөн орнуудын туршлага бий. Энэ нь ХБХ-д хамааралгүй ямар нэг бодлого, шийдвэр байдаггүйтэй холбоотой.
52	40	ХБХ-ий асуудлыг дагнан эрхлэх төрийн захиргааны байгууллагыг МУ-ын Ерөнхий сайдын шууд харьяанд байгуулах, 40.5 ХБХ-ий эрхийг хангах, хэрэгжүүлэх, дээрх чиглэлээр явуулах үйл ажиллагаа, үйлчилгээг санхүүжүүлэх зорилгоор ХБХ-ий Хөгжлийн санг байгуулах 40.6 40.5-д заасан сангийн үйл ажиллагааг ЗГ-ын тусгай сангийн тухай хуулиар зохицуулах ба холбогдох журмыг ХБХ-ий асуудал эрхэлсэн, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	ХБХ-ий чиглэлээр явуулдаг олон үйл ажиллагаа, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх тодорхой эх үүсвэр байдаггүй учраас хууль бүрэн хэрэгждэггүй. Иймд тусгай санг байгуулах зайлшгүй шаардлагатай бөгөөд ХБХ, байгууллагууд энэ асуудлыг байнга тавьдаг.
53	41.1	“байгуулан ажиллуулж болно” гэснийг “байгуулах” гэж солих, Орон тооны бус зөвлөлийг Ерөнхий сайдын дэргэд ажиллуулах	Орон тооны бус зөвлөл Ерөнхий сайдын дэргэд байснаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэд очсоноор үйл ажиллагаа, шийдвэр, биелэлт эрс муудсан.
54	41.3	“Зөвлөлийн ажлын албаны үүргийг хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гүйцэтгэнэ.”	ХБХ-ий асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Ерөнхий сайдын дэргэд байх тохиолдолд Орон тооны бус зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэх боломжтой.
55	45	Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгож Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд тусгах	Амьдрал дээр албан тушаалтнууд энэ хуулийг зөрчих тохиолдол маш их байна.

Гурав. ДАГАЛДАН ГАРАХ БУСАД ХУУЛИЙН САНАЛ

№	Зүйл, заалт	Санал	Тайлбар үндэслэл
1	Сонгуулийн тухай хууль	27.2-р заалтад “...5-аас доошгүй хувь нь ХБХ-ий төлөөлөл байна” гэж нэмэх	ХБХ-ий сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд квот гол арга зам болно.
2	Автотээврийн тухай хууль	“14.3. ХБХ-ий эзэмшиж буй автотээврийн хэрэгслийг энэ хуулийн 14.2-т зааснаас гадна аймаг, нийслэл, орон нутгийн хэмжээнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулахдаа аливаа хязгаарлалтад хамруулахыг хориглоно.” гэсэн заалт нэмэх	ХБХ нийтийн тээврийн хэрэгслээр бие даан чөлөөтэй зорчих боломжгүй үед тээврийн хэрэгслийг нь дугаарын, эгнээ байрлалын хязгаарлалтад хамруулах нь хүндрэл учруулж байна.
3	Эрүүгийн хууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6.1.-6.5. заалтыг зөрчиж, ялгаварлан гадуурхсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх өөрчлөлтийг Эрүүгийн хуулийн 14.1-р зүйлд нэмж тусгах	Эрүүгийн хуулийн 14.1-р зүйлээр хуулийн этгээд хариуцлага хүлээхгүй байгаа тул
4	Зөрчлийн тухай хууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй этгээдэд хүлээлгэх хариуцлагыг хуульд нэмж тусгах	Хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуульд огт тусгаагүй тул хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Оролцогчдын нэрс

- | | | |
|--|--|---|
| 1. Я.АВИРМЭД, Түгээмэл хөгжил ТББ | 16. О.ГАНЧУЛУУН, Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрх ашгийг хамгаалах төв ТББ | мэдээллийн төв ТББ |
| 2. П.ГЭСЭР, Түгээмэл хөгжил ТББ | 17. Б.ГҮНЖИЛМАА, ХБИ-ийн бизнес инкубатор төв ТББ | 29. Б.САРАНЧИМЭГ, Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв |
| 3. Б.НЯМ-ОЧИР, Түгээмэл хөгжил ТББ | 18. Д.ГЭРЭЛ, МХҮХ ТББ | 30. Б.ТҮНЭРЭВ, Буян бат ТББ |
| 4. н.АЛТАНЗУЛ, Сэлэнгэ аймгийн ХБИ-ийн холбоо ТББ | 19. Д.ЗОЛЖАВХЛАН, Ээлтэй ертөнц ТББ | 31. Т.ЦЭДЭНБАА, Сонсголын бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын нэгдсэн холбоо ТББ |
| 5. Г.АРИУНБОЛД, Энх нийгэм ТББ | 20. Т.ТУЯАЖАРГАЛ, Ээлтэй ертөнц ТББ | 32. Э.ЦЭНГЭЛ, Энэрэлийн түүчээ ТББ |
| 6. Д.БААТАРЖАВ, МХБИ-ийн Нэгдсэн холбоо ТББ | 21. Ц.МИНЖЭЭ, Шинэ хос номын оюу ТББ | 33. Л.ЦЭРЭНГААМАА, Таны төлөө халуун сэтгэл ТББ |
| 7. А.БАРХАС, Эрүүл мэндийн яам | 22. Ч.МИШЭЭЛ, БХБЯ, Бодлого төлөвлөлтийн газар | 34. М.ЧУЛУУН-ЭРДЭНЭ, ХБ-тэй хүний хөгжлийн агентлаг мэргэжилтэн ТББ |
| 8. Ө.БАТБАЯР, “Best knowledge” сургалтын төв | 23. Ц.МӨНХСАРУУЛ, МХБИ-ийн холбоо ТББ | 35. А.ЭНХБААТАР, Монгол улсын Сонсголгүй иргэдийн Үндэсний холбоо ТББ |
| 9. Д.БАТБОЛД, Адил хүртээмж ТББ | 24. П.МӨНХТУЛГА, НДЕГ, ЭХМТК (Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төвийн комисс) | 36. Л.ЭНХБАЯР, МХБИ-ийн чөлөөт үйлдвэрчний эвлэлийн холбоо |
| 10. Д.БАТЗАЯА, Элэгсэг оршихуй ТББ | 25. Б.МЯДАГ, Дохионы хэлний орчуулагч | 37. Н.ЭНХБАЯР, ХБИ-ийн сургалт мэдээллийн төв ТББ |
| 11. А.БАТ-ОТГОН, МХБИ-ийн Нэгдсэн холбоо ТББ | 26. Н.НЯМЖАВ, ХБ-тэй хүүхдийн төлөө нэгдсэн холбоо ТББ | 38. Д.ЭНХЗАЯА, Билгүүн-Үзэг ТББ |
| 12. Ю.БАТ-ЭРДЭНЭ, Бат-Эгшиглэн ТББ | 27. Б.ОТГОНТУЯА, Бид чадна ТББ | 39. Р.ЭНХЧУЛУУН, Марал-Элч сан ТББ |
| 13. Г.БОЛОРМАА, Монголын харааны бэрхшээлтэй хүүхэд залуучуудын холбоо ТББ | 28. Т.САЙНСАНАА, ХБИ-ийн сургалт | 40. П.ЭРДЭНЭТОГТОХ, Өэлүн эхийн ачлал ХХК, Сургалтын төв |
| 14. Б.БОЛООРОО, ХНХЯ | | |
| 15. Г.БУЯНЖАРГАЛ, Монголын тархины сааны холбоо ТББ | | |

Дугаарыг эрхэлсэн: **Б.ХИШИГСАЙХАН**
ННФ-ын Засаглалын
хөтөлбөрийн менежер

Хамтарч ажилласан: **ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ**
ИРГЭДИЙН БАЙГУУЛААГУУД



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn